

“АЗИ ДАХЬ АРДЧИЛСАН ШИЛЖИЛТ” ОЛОН УЛСЫН СЕМИНАР БОЛЖ БАЙНА

Written by hanoi

Monday, 21 March 2016 02:06 - Last Updated Monday, 21 March 2016 02:12

There are no translations available.

Гадаад хэргийн яам, Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хврээлэн (International IDEA)-тэй хамтран “Ази дахь ардчилсан шилжилт” сэдэвт олон улсын семинарыг 3 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд зохион байгуулж байна.

Тус семинарын гол зорилго нь ардчиллыг хөгжүүлэх, бэхжүүлэх чиглэлээр Монгол Улсын олсон ололт амжилт, тулгарсан сорилтуудыг бусад улс орнуудтай хуваалцах, ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оршино.

Семинарт Афганистан, Бутан, Камбож, Киргиз, Непал, Мьянмар, Зүүн Тимор, Шри Ланк, Индонез, Лаос зэрэг 10 гаруй орны Засгийн газрын болон иргэний нийгмийн толоологчид оролцож, ардчиллын үнэт зарчим болсон сонгуулийн асуудлаар илтгэл тавьж, санал бодлоо солилцоно.

Хууль зүйн яамны торийн нарийн бичгийн дарга Ж.Баярцэцэг семинарыг нээж хэлсэн үгэндээ Монгол Улс 26 жилийн олно ардчилсан тогтолцоонд шилжиж анхны бие даасан, хараат бус сонгуулийн байгууллага байгуулагдаж, сонгуулийн эрх зүйн орчин, сонгуулийн тогтолцооны хувьд бус нутагтаа үлгэр жишээ үзүүлэхийц улс болж байгааг онцлов. Мөн тэрээр оорийн орны туршлагыг ардчилалд шилжиж буй бусад улс оронтой хуваалцаж, хамтран ажиллаж байгаа талаар дэлгэрэнгүй мэдээлсэн байна.

Семинар бүтэн 2 өдрийн турш үргэлжилж Ардчиллыг хөгжүүлж байгаа туршлага, сонгуулийн сургамж болон сонгуулийг шударга, нээлттэй явуулах боломж зэрэг асуудлаар торийн болон иргэний нийгмийн толоологчид санал бодлоо солилцоно.